

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА- 2024\76\НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.25 № 01/173  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Ц.ХОРОЛГАРАВ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан; тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 4 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 76,2 хувиар хэрэгжүүлсэн байна

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

019999997

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	96,183,636.70	136,950,964.57
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨ	18,907,612.56	50,098,465.16
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,907,612.56	50,098,465.16
9	Төгрөг	18,907,612.56	50,098,465.16
10	Төрийн сангийн харилцах	18,907,612.56	50,098,465.16
27	АВЛАГА	-	3,837,048.00
29	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	3,837,048.00
60	БАРАА МАТЕРИАЛ	77,276,024.14	83,015,451.41
61	Түүхий эд материал	37,155,624.52	54,578,699.99
63	Эм боох материал	37,155,624.52	54,578,699.99
66	Хангамжийн материал	39,686,399.62	28,436,751.42
67	Бичиг хэргийн материал	2,239,660.00	1,485,870.00
68	Аж ахуйн материал	28,036,120.62	23,645,560.42
70	Түлш шатах тослох материал	4,007,968.00	-
71	Барилгын засварын материал	2,933,000.00	2,600,000.00
72	Хүнсний материал	2,469,651.00	705,321.00
75	Мал, амьтад	434,000.00	-
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	651,681,993.35	615,613,029.99
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	651,681,993.35	615,613,029.99
108	Биет хөрөнгө	637,681,993.35	601,298,530.02
109	Барилга, байгууламж	514,843,120.00	514,843,120.00
110	Хуримтлагдсан элэгдэл	(57,365,776.32)	(71,707,220.40)
111	Авто тээврийн хэрэгсэл	79,570,000.00	74,950,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(44,980,000.08)	(53,949,999.88)
113	Машин, тоног төхөөрөмж	278,600,145.08	274,425,668.64
114	Хуримтлагдсан элэгдэл	(159,769,924.26)	(157,008,671.67)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,884,206.55	43,297,568.06
116	Хуримтлагдсан элэгдэл	(20,202,277.62)	(24,654,434.73)
122	Бусад үндсэн хөрөнгө	19,752,780.00	19,752,780.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(19,752,780.00)	(19,752,780.00)
125	Номын фонд	1,102,500.00	1,102,500.00
126	Биет бус хөрөнгө	14,000,000.00	14,314,499.97
127	Програм хангамж	445,000.00	815,000.00
128	Хасагдуулга	(445,000.00)	(500,500.03)
129	Бусад биет бус хөрөнгө	14,000,000.00	14,000,000.00
137	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>747,865,630.05</b>	<b>752,563,994.56</b>
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	747,865,630.05	752,563,994.56
215	Засгийн газрын хувь оролцоо	747,865,630.05	752,563,994.56
216	Засгийн газрын оруулсан капитал /З	661,388,636.04	661,388,636.04
217	Өмч: -Төрийн өмч	661,388,636.04	661,388,636.04
223	Хуримтлагдсан үр дүн	(86,807,357.02)	(81,925,683.37)
224	Өмнөх үеийн үр дүн	(86,807,357.02)	(86,624,047.88)
225	Тайлант үеийн үр дүн	-	4,698,364.51
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	173,284,351.03	173,101,041.89
231	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/Ө</b>	<b>747,865,630.05</b>	<b>752,563,994.56</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	634,607,979.18	589,267,955.81
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,077,259.08	64,772,922.31
77	Нийтлэг татварын бус орлого	88,077,259.08	64,772,922.31
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	88,077,259.08	64,772,922.31
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	50,000.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	88,077,259.08	64,722,922.31
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	546,530,720.10	524,495,033.50
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00	-
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	250,000.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,362,500.00	38,223,000.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,362,500.00	38,223,000.00
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	512,918,220.10	486,272,033.50
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас	512,918,220.10	486,272,033.50
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	637,828,878.02	584,135,591.30
148	УРСГАЛ ЗАРДАЛ	637,828,878.02	584,135,591.30
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	637,828,878.02	581,222,829.13
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	331,793,715.21	337,952,979.53
151	Цалин	228,012,007.77	222,503,225.72
152	Нэмэгдэл цалин	69,600,243.44	70,843,918.06
153	Унаа хоолны хөнгөлөлт	3,723,000.00	4,028,000.00
154	Урамшуулал	30,458,464.00	40,577,835.75
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,550,914.52	44,084,804.87
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	45,866,430.91	31,017,990.71
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,232,491.85	3,649,177.19
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,488,553.39	2,778,541.77
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	542,130.81	603,554.17
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,421,307.56	6,035,541.03
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,325,634.00	34,110,237.83
165	Гэрэл цахилгааны зардал	3,809,197.00	4,148,628.83
166	Түлш, халаалтын зардал	28,159,437.00	29,511,609.00
167	Цэвэр, бохир усны зардал	357,000.00	450,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	48,460,924.00	20,462,493.00
171	Бичиг хэргийн материал	3,777,130.00	2,105,870.00
172	Тээвэр, шатахууны зардал	24,670,582.00	14,212,617.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,528,890.00	1,261,100.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	18,484,322.00	2,882,906.00
181	Нормативт зардал	64,575,740.22	47,325,032.08
182	Эм	52,914,502.72	39,368,752.08
183	Хоол	11,661,237.50	7,956,280.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	12,147,100.00	5,244,000.00
186	Багаж хэрэгсэл	385,000.00	791,000.00
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,810,600.00	995,000.00
189	Урсгал засвар	6,951,500.00	3,458,000.00
190	Томилолт, зочны зардал	1,700,600.00	1,544,000.00

194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	825,550.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зард	-	576,000.00
197	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	79,500.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	-	64,700.00
199	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	91,000.00
201	Газрын төлбөр	-	14,350.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	89,274,250.07	89,673,731.82
210	Бараа үйлчилгээний бусад зардал	31,486,944.81	14,915,389.40
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,787,305.26	74,758,342.42
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,912,762.17
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,912,762.17
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,912,762.17
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(3,220,898.84)	5,132,364.51
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	434,000.00
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	0.00
281	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	434,000.00
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(434,000.00)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(3,220,898.84)	4,698,364.51

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	587,654,186.84	520,707,985.50
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	50,000.00
78	Нийтлэг татварын бус орлого	-	50,000.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	50,000.00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	50,000.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	587,654,186.84	520,657,985.50
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,866,966.74	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	250,000.00	-
128	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих - Нэмэлт	2,616,966.74	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,362,500.00	38,223,000.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,362,500.00	38,223,000.00
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүж	551,424,720.10	482,434,985.50
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	551,424,720.10	482,434,985.50
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	546,069,141.02	487,895,132.90
148	УРСГАЛ ЗАРДАЛ	546,069,141.02	487,895,132.90

149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,452,174.28	484,982,370.73
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	335,370,673.07	337,955,623.30
151	Үндсэн цалин	229,297,224.63	219,968,019.11
152	Нэмэгдэл	72,147,236.44	71,030,540.81
153	Унаа хоолны хөнгөлөлт	3,697,000.00	3,328,000.00
154	Үр дүнгийн урамшуулал	30,229,212.00	43,629,063.38
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	53,672,599.63	44,082,161.10
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	41,528,177.07	30,899,431.75
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,134,926.51	3,580,266.56
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,470,961.16	2,749,733.30
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	582,570.63	608,798.19
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,955,964.26	6,243,931.30
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	32,162,500.00	34,110,237.83
165	Гэрэл цахилгааны зардал	3,809,197.00	4,148,628.83
166	Түлш, халаалтын зардал	27,996,303.00	29,511,609.00
167	Цэвэр, бохир усны зардал	357,000.00	450,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	37,371,640.00	15,235,669.00
171	Бичиг хэрэг	5,164,200.00	1,779,120.00
172	Тээвэр, шатахуун	28,678,550.00	10,204,649.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,528,890.00	1,261,100.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,990,800.00
181	Нормативт зардал	60,851,000.00	42,613,279.50
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,951,000.00	37,268,429.50
183	Хоол, хүнс	10,900,000.00	5,344,850.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	15,015,500.00	6,359,550.00
186	Багаж техник хэрэгсэл	815,500.00	2,239,550.00
188	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	4,000,000.00	995,000.00
189	Урсгал засвар	10,200,000.00	3,125,000.00
190	Томилолт, зочны зардал	1,700,600.00	1,544,000.00
192	Дотоод албан томилолт	1,700,600.00	1,544,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	825,550.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	432,000.00
197	Даатгалын үйлчилгээ	-	79,500.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	-	208,700.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	0
2	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.03	(192,800,134.22)	641,872,852.85
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.03	(192,800,134.22)	641,872,852.85
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдаг	0	0	(8,860,503.84)	(8,860,503.85)
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.03	(86,807,357.02)	747,865,630.05
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.03	(86,807,357.02)	747,865,630.05
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөр	0		183,309.13	183,309.14
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.03	(86,624,047.88)	748,048,939.19
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөл	0	(183,309.14)		(183,309.14)
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдаг	0	0	4,698,364.51	4,698,364.51
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	661,388,636.04	173,101,041.89	(81,925,683.37)	752,563,994.56

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үл	-	18,907,612.56	(18,907,612.56)	
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮ	638,466,600.00	486,604,370.73	151,862,229.27	76.2
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	638,466,600.00	486,604,370.73	151,862,229.27	76.2
4	Бараа, үйлчилгээний зардал	638,466,600.00	486,604,370.73	151,862,229.27	76.2
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,483,600.00	337,955,623.30	113,527,976.70	74.9
6	Үндсэн цалин	276,885,500.00	219,968,019.11	56,917,480.89	79.4
7	Нэмэгдэл	91,314,200.00	71,030,540.81	20,283,659.19	77.8
8	Унаа, болон бусад нөхөн олговор	3,880,800.00	3,328,000.00	552,800.00	85.8
9	Урамшуулал	79,403,100.00	43,629,063.38	35,774,036.62	54.9
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ш	52,356,200.00	44,082,161.10	8,274,038.90	84.2
12	Тэтгэврийн даатгал	35,601,000.00	30,899,431.75	4,701,568.25	86.8
13	Тэтгэмжийн даатгал	4,188,000.00	3,580,266.56	607,733.44	85.5
14	ҮОМШӨ ний даатгал	3,350,700.00	2,749,733.30	600,966.70	82.1
15	Ажилгүйдлийн даатгал	839,000.00	608,798.19	230,201.81	72.6
16	Эрүүл мэндийн даатгал	8,377,500.00	6,243,931.30	2,133,568.70	74.5
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зарда	37,023,000.00	34,110,237.83	2,912,762.17	92.1
18	Гэрэл цахилгаан	6,486,600.00	4,148,628.83	2,337,971.17	64.0
19	Түлш, халаалт	29,936,400.00	29,511,609.00	424,791.00	98.6
20	Цэвэр, бохир ус	600,000.00	450,000.00	150,000.00	75.0
22	Хангамж, бараа материалын зардал	23,169,900.00	15,235,669.00	7,934,231.00	65.8
23	Бичиг хэрэг	3,840,500.00	1,779,120.00	2,061,380.00	46.3
24	Тээвэр (шатахуун)	15,890,500.00	10,204,649.00	5,685,851.00	64.2
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,448,100.00	1,261,100.00	187,000.00	87.1
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн у	1,990,800.00	1,990,800.00	-	100.0
30	Нормативт зардал	45,788,100.00	42,613,279.50	3,174,820.50	93.1
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	37,406,000.00	37,268,429.50	137,570.50	99.6
32	Хоол, хүнс	8,382,100.00	5,344,850.00	3,037,250.00	63.8
34	Эд хогшил худалдан авах	9,700,000.00	6,359,550.00	3,340,450.00	65.6
35	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	2,239,550.00	2,760,450.00	44.8
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,000,000.00	995,000.00	5,000.00	99.5
38	Урсгал засвар	3,700,000.00	3,125,000.00	575,000.00	84.5

39	Томилолт, зочны зардал	2,392,200.00	1,544,000.00	848,200.00	64.5
41	Дотоод албан томилолт	2,392,200.00	1,544,000.00	848,200.00	64.5
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	1,015,300.00	825,550.00	189,750.00	81.3
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох за	432,000.00	432,000.00	-	100.0
46	Даатгалын үйлчилгээ	139,000.00	79,500.00	59,500.00	57.2
47	Тээврийн хэрэгслийн татвар	261,200.00	208,700.00	52,500.00	79.9
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	111,000.00	91,000.00	20,000.00	82.0
50	Газрын төлбөр	72,100.00	14,350.00	57,750.00	19.9
53	Бараа үйлчилгээний бусад зардал	15,538,300.00	3,878,300.00	11,660,000.00	25.0
54	Бараа үйлчилгээний бусад зардал	15,538,300.00	3,878,300.00	11,660,000.00	25.0
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	638,466,600.00	520,707,985.50	117,758,614.50	81.6
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,223,000.00	38,223,000.00	-	100.0
104	Орон нутгийн төсвөөс	38,223,000.00	38,223,000.00	-	100.0
106	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	581,336,000.00	482,434,985.50	98,901,014.50	83.0
108	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүж	581,336,000.00	482,434,985.50	98,901,014.50	83.0
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГА	18,907,600.00	50,000.00	18,857,600.00	0.3
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүж	-	50,000.00	(50,000.00)	
113	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	18,907,600.00	-	18,907,600.00	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үл	-	18,907,612.56	(18,907,612.56)	
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үл	-	50,098,465.16	(50,098,465.16)	
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	21.00	19.00	2.00	90.5
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
135	Гүйцэтгэх ажилтан	15.00	13.00	2.00	86.7
136	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн чиглэлийн үйл ажиллагаа үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оныг "Эх хүүхдийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 4 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 98,2 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь батлагдсан орон тоо 21 гүйцэтгэлээр 19 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,

- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр сумын Засаг даргын нэрэмжит шалгалтаар 92,0 хувьтай, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээ шинжилгээний шалгалтаар 96,0 хувьтай тус тус дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,698.3 мянган төгрөгөөр буюу 0,63 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,907.6	50,098.4	31,190.8
Авлага		3,837.0	3,837.0
Урьдчилгаа			
Бараа материал	77,276.0	83,015.4	5,739.4
Үндсэн хөрөнгө	651,681.9	615,613.0	-36,068.9

<b>Нийт хөрөнгө</b>	<b>747,865.6</b>	<b>752,563.9</b>	<b>4,698.3</b>
<b>Өр төлбөр</b>			
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	747,865.6	752,563.9	4,689.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>747,865.6</b>	<b>752,563.9</b>	<b>4,698.3</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 50,098.4 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 31,190.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 3 орон тоо дутуу ажилласан, оны эхний 3 сар шатахууны талоны нөөцтэй байсан зэргээс шалтгаалсан.

Авлага данс 3,837.0 мянган төгрөг байгаа нь Нийгмийн даатгалын сангаас авах авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 5,739.4 мянган төгрөгөөр өссөн нь:

- Улсын төсвийн хөрөнгөөр 63,758.1 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл боох материал, хүнсний материал, аж ахуйн бараа материал худалдан авсан.
- Хандиваар 17,056.2 мянган төгрөгийн эм эмийн хэрэгсэл, боох материал үнэ төлбөргүй хүлээн авсан.
- Бараа материал данснаас байгууллагын үйл ажиллагаанд 85,240.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Мал эмнэлгийн мэргэжилтний актаар 434.0 мянган төгрөгийн мал акталсан.

Үндсэн хөрөнгө данс нь оны эцэст 1.826.660.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 226,627.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны дэлгэрэнгүй бүртгэлээс харахад:

- 1,622.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгөөр, 37,067.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар тус тус авсан.
- 50,837,9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан
- Сумын ИТХ-н 2023 оны 3 сарын 29 ний өдрийн 04 тоот тогтоолоор 49,700.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын 600,243.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 33,223.0 мянган төгрөг нийт зарлагыг 638,466.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 638,466.6 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 638,466.6 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 600,243.6

мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 33,223.0 мянган төгрөгийг тус тус бүрдүүлсэн ба нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 638,466.6 мянган төгрөг байна.

.Төсвийн зардлын гүйцэтгэл 486,604.3 мянган төгрөг буюу 76,2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нийт 151,862.2 мянган төгрөгөөр, үүнээс цалин нэмэгдэл, урамшууллын зардлыг 113,527.9 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардлыг 2,912.7 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 7,934.2 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 3,174.8 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 3,340.4 мянган төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

				/мянган төгрөгөөр/	
д/д	71802 Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80302	Нэг иргэнд ноогдох нормативаар	441,664.9	367,211.6	74,453.3	83,1%
81603	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	139,671.1	71,598.1	68,072.9	51,3%
83603	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	18,907.6	12,484.4	6,423.2	66,0%
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	38,223.0	35,310.2	2,912.7	92,4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

**3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

**Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт**

							/мянган төгрөгөөр/
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан	
1	71802-80302	2023-12-31	1 иргэнд ноогдох нормативаар	83,1%	441,664.9	367,211.6	
2	71802-81605	2023-12-31	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	51,3%	139,671.1	71,598.1	
3	71802-83603	2023-12-31	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	66,0%	18,907.6	12,484.4	
4	71802-	2023-12-31	Төрийн өмчийн	92,4%	38,223.0	35,310.2	

	80111		барилгын тогтмол зардал		
--	-------	--	-------------------------	--	--

Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ болон 1 иргэнд ноогдох нормативт зардал арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь орон тоо дутуу, цалин, нэмэгдэл хэмнэснээс шалтгаалсан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт 1,058.2 мянган төгрөгийн эм эмийн хэрэгсэл авсан байна. Тендер шалгаруулсан газруудаас эм, эмийн хэрэгсэл боох материал, хүнсний материал зэргийг нийлүүлдэг. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,045,000,0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 20,900,0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16,720,0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж

ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 4 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 113,527.9 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 6,253.2 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 8,123.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 157 мэдээллийг байршуулж 2 мэдээллийн хугацаа нь болоогүй хүлээгдэж байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн эхний 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон санхүүгийн тайланд хийгдсэн Завсрын аудитын явцад биологийн хөрөнгийн болон зардлын данстай холбоотой 491.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 2 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,697.2	1	1,697.2	100
Албан шаардлага	2	19,110.5	2	19,110.5	100
Зөвлөмж					100
Нийт дүн	3	20,807.7	3	20,807.7	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүсэж байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 949.1 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 257.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 434.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 257.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

1.Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт: Хүнсний зарцуулалт нормыг баримтлаагүй 257.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/74 тоот тушаалын 3-р хавсралтаар батлагдсан жишиг нормыг баримтлаагүй болон “Эрх ба үүрэг” мөн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг ханган ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.6-д “Эрх бүхий этгээдээс тогтоосон норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн орц нормыг хэтрүүлэн зарцуулсан 257.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

1.Хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бүртгэлээр мал байгаа боловч биет байдлаар байхгүй зудад үхсэн гэх боловч акт шийдвэр байхгүй 434.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.2-т “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн холбогдох тушаал зааврыг дагаж мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

1.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шатахууны батлагдсан нормыг мөрдөж ажиллаагүй 257.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-5-р хавсралт автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны жишиг нормыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид жолоочийн бензин зарцуулалтыг нормын дагуу бодож ажиллах

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүнсний зарцуулалтын нормыг баримтлаагүй	1	257.2	1	257.2								
Бүртгэлээр мал амьтан байгаа боловч биет байдлаар байхгүй. Зудад үхсэн гэсэн боловч акт шийдвэр байхгүй.	1	434.0			1	434.0						
Шатахууны батлагдсан нормыг мөрдөж ажиллах	1	257.9					1	257.9				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>949.1</b>	<b>1</b>	<b>257.2</b>	<b>1</b>	<b>434.0</b>	<b>1</b>	<b>257.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)